НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

# Нийслэлийн Багануур дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/654/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

Аудитор: Д.Баасанням
Утас: 325093 Цахим хаяг: Baasannyam@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/147

танай ____________-ны № ____________-т

НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР
ДҮҮРГИЙН ХҮҮХЭД, ГЭР
БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Т.ХАШЛЯНХУА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Багануур дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь хүүхдийн хөгжил, хамгаалал хөтөлбөрийн хүрээнд эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх гэсэн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр төсвийн төслийг боловсруулахдаа тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагыг судалж, нөхцөл байдал, эрсдэлийг үнэлээгүй, шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд хамтарсан багийн гишүүдийг ажлын байранд чадавхжуулах, гэр бүл, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, жендерийн тухай ойлголт, угийн бичиг хөтлөх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол сэдэвт сургалтууд, цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаарх суурь судалгаа хийх зэрэг ажлыг зохион байгуулж төсвөөс 17,669.1 мянган төгрөг зарцуулсан байна.

**Бусад асуудал**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.7 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.25.BND.HGBHHH.docx

02023575

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\erdmene.d\Desktop\2025\Word\Ysan bichig\2025.02.25.BND.HGBHHH.docx

## Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **51,795,510.00** | **54,132,510.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 51,795,510.00 | 54,132,510.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 51,795,510.00 | 54,132,510.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 132,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,090,000.00 | 2,990,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 50,705,510.00 | 51,010,510.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **222,802,145.07** | **262,155,547.41** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 222,802,145.07 | 262,155,547.41 |
| **392** | **Биет хөрөнгө** | 77,607,145.07 | 122,960,547.41 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 85,903,207.08 | 85,903,207.08 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -32,249,755.50 | -38,380,425.04 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 00.00 | 29,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -2,475,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 25,476,103.60 | 57,765,003.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -19,808,980.55 | -21,893,480.67 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,913,492.93 | 28,913,492.93 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -21,488,492.93 | -22,745,992.93 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 24,968,141.00 | 24,968,141.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -14,106,570.56 | -18,794,398.56 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 145,195,000.00 | 139,195,000.00 |
| 39301 | Програм хангамж | 600,000.00 | 600,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -600,000.00 | -600,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 145,195,000.00 | 139,195,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **274,597,655.07** | **316,288,057.41** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **274,597,655.07** | **316,288,057.41** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 274,597,655.07 | 316,288,057.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 184,195,579.83 | 184,195,579.83 |
| 51101 | Өмч: - төрийн | 184,195,579.83 | 184,195,579.83 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 41,070,982.07 | 88,761,384.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 64,374,389.95 | 41,070,982.07 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -23,303,407.88 | 47,690,402.34 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 49,331,093.17 | 43,331,093.17 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **274,597,655.07** | **316,288,057.41** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **432,100,700.00** | **699,533,880.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **52,009,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 52,009,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 52,009,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **432,100,700.00** | **647,524,880.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 352,092,500.00 | 632,248,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 352,092,500.00 | 632,248,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 80,008,200.00 | 15,276,880.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 9,060,800.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 250,000.00 | 3,250,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 69,950,000.00 | 11,660,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 747,400.00 | 366,880.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **454,355,521.71** | **651,843,477.66** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **454,355,521.71** | **651,843,477.66** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 340,645,285.30 | 618,999,479.18 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 206,729,170.69 | 385,448,901.52 |
| 210101 | Үндсэн цалин | 142,621,340.72 | 214,619,425.09 |
| 210102 | Нэмэгдэл | 11,399,920.77 | 71,668,132.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,921,302.34 | 72,136,127.78 |
| 210104 | Урамшуулал | 19,786,606.86 | 27,025,216.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,774,962.90 | 48,389,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,352,244.66 | 33,452,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,356,099.66 | 3,734,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,686,879.69 | 1,867,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 392,822.88 | 1,867,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,986,916.01 | 7,468,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 00.00 | 33,915,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 00.00 | 33,915,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,282,240.00 | 8,629,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,064,100.00 | 3,822,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,087,100.00 | 916,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,868,800.00 | 1,833,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 458,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,262,240.00 | 1,599,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 913,500.00 | 822,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 913,500.00 | 822,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 52,906,990.00 | 123,303,180.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 51,815,200.00 | 122,834,280.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 468,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,091,790.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 36,038,421.71 | 18,491,397.66 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,000,000.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,352,600.00 | 1,855,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 16,685,821.71 | 16,635,497.66 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 113,710,236.41 | 32,843,998.48 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 980,200.00 | 30,243,046.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 20,611,346.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 8,670,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 980,200.00 | 961,600.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 112,730,036.41 | 2,600,952.48 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 112,730,036.41 | 2,600,952.48 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-22,254,821.71** | **47,690,402.34** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,048,586.17 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,048,586.17 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,048,586.17 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-23,303,407.88** | **47,690,402.34** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **432,175,413.00** | **647,524,880.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **74,713.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 74,713.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 74,713.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 74,713.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **432,100,700.00** | **647,524,880.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 352,092,500.00 | 632,248,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 352,092,500.00 | 632,248,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 80,008,200.00 | 15,276,880.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 9,060,800.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 250,000.00 | 3,250,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 69,950,000.00 | 11,660,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 747,400.00 | 366,880.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **432,175,413.00** | **647,524,880.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **432,175,413.00** | **647,524,880.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **318,465,176.59** | **614,680,881.52** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 206,729,170.69 | 385,448,901.52 |
| 210101 | Үндсэн цалин | 142,621,340.71 | 214,619,425.09 |
| 210102 | Нэмэгдэл | 11,399,920.77 | 71,668,132.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,921,302.40 | 72,136,127.78 |
| 210104 | Урамшуулал | 19,786,606.81 | 27,025,216.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,774,962.90 | 48,389,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,352,244.66 | 33,452,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,356,099.66 | 3,734,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,686,879.69 | 1,867,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 392,822.88 | 1,867,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,986,916.01 | 7,468,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 33,915,000.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 33,915,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,908,540.00 | 8,930,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,027,100.00 | 3,943,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,750,400.00 | 916,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,868,800.00 | 1,833,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 458,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,262,240.00 | 1,779,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 9,979,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 9,979,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 913,500.00 | 822,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 913,500.00 | 822,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 49,786,403.00 | 125,339,180.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 48,694,613.00 | 124,870,280.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 468,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,091,790.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,352,600.00 | 1,855,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,000,000.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,352,600.00 | 1,855,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **113,710,236.41** | **32,843,998.48** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 980,200.00 | 30,243,046.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 20,611,346.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 8,670,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 980,200.00 | 961,600.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 112,730,036.41 | 2,600,952.48 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 112,730,036.41 | 2,600,952.48 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 184,195,579.83 | 49,595,779.78 | 64,109,703.34 | - | 297,901,062.95 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **184,195,579.83** | **49,595,779.78** | **64,109,703.34** | **-** | 297,901,062.95 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (23,303,407.88) | - | (23,303,407.88) |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **184,195,579.83** | **49,595,779.78** | **40,806,295.46** | **-** | 274,597,655.07 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **184,195,579.83** | **49,595,779.78** | **40,806,295.46** | **-** | 274,597,655.07 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **184,195,579.83** | **49,595,779.78** | **40,806,295.46** | **-** | 274,597,655.07 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (6,000,000.00) | - | - | (6,000,000.00) |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 47,690,402.34 | - | 47,690,402.34 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **184,195,579.83** | **43,595,779.78** | **88,496,697.80** | **-** | 316,288,057.41 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| **Үзүүлэлт** | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **632,248,000.00** | **629,647,047.52** | **2,600,952.48** | **99.6** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **632,248,000.00** | **629,647,047.52** | **2,600,952.48** | **99.6** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **601,808,100.00** | **599,404,001.52** | **2,404,098.48** | **99.6** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **387,112,400.00** | **385,448,901.52** | **1,663,498.48** | **99.6** |
| Үндсэн цалин | 231,896,400.00 | 214,619,425.09 | 17,276,974.91 | 92.5 |
| Нэмэгдэл | 117,193,900.00 | 71,668,132.65 | 45,525,767.35 | 61.2 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 16,202,400.00 | 72,136,127.78 | (55,933,727.78) | 445.2 |
| Урамшуулал | 21,819,700.00 | 27,025,216.00 | (5,205,516.00) | 123.9 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **48,389,100.00** | **48,389,100.00** | **-** | **100.0** |
| Тэтгэврийн даатгал | 33,452,500.00 | 33,452,500.00 | - | 100.0 |
| Тэтгэмжийн даатгал | 3,734,200.00 | 3,734,200.00 | - | 100.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,867,000.00 | 1,867,000.00 | - | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 1,867,100.00 | 1,867,100.00 | - | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 7,468,300.00 | 7,468,300.00 | - | 100.0 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **34,623,000.00** | **33,915,000.00** | **708,000.00** | **98.0** |
| Гэрэл, цахилгаан | 618,400.00 | - | 618,400.00 | - |
| Байрны түрээс | 34,004,600.00 | 33,915,000.00 | 89,600.00 | 99.7 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **8,930,400.00** | **8,930,400.00** | **-** | **100.0** |
| Бичиг хэрэг | 3,943,000.00 | 3,943,000.00 | - | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 916,600.00 | 916,600.00 | - | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,833,300.00 | 1,833,300.00 | - | 100.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 458,300.00 | 458,300.00 | - | 100.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,779,200.00 | 1,779,200.00 | - | 100.0 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,000,000.00** | **9,979,900.00** | **20,100.00** | **99.8** |
| Багаж, техник, хэрэгсэл | 10,000,000.00 | 9,979,900.00 | 20,100.00 | 99.8 |
| **Томилолт, зочны зардал** | **835,000.00** | **822,500.00** | **12,500.00** | **98.5** |
| Дотоод албан томилолт | 835,000.00 | 822,500.00 | 12,500.00 | 98.5 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **110,062,300.00** | **110,062,300.00** | **-** | **100.0** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 109,593,400.00 | 109,593,400.00 | - | 100.0 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 468,900.00 | 468,900.00 | - | 100.0 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,855,900.00** | **1,855,900.00** | **-** | **100.0** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,855,900.00 | 1,855,900.00 | - | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **30,439,900.00** | **30,243,046.00** | **196,854.00** | **99.4** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **30,439,900.00** | **30,243,046.00** | **196,854.00** | **99.4** |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,805,300.00 | 20,611,346.00 | 193,954.00 | 99.1 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,673,000.00 | 8,670,100.00 | 2,900.00 | 100.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 961,600.00 | 961,600.00 | - | 100.0 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **632,248,000.00** | **629,647,047.52** | **2,600,952.48** | **99.6** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **632,248,000.00** | **629,647,047.52** | **2,600,952.48** | **99.6** |
| Улсын төсвөөс санхүүжих | 632,248,000.00 | 629,647,047.52 | 2,600,952.48 | 99.6 |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **14** | **14** | **-** | **100.0** |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 11 | 11 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 2 | 2 | - | 100.0 |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **14** | **14** | - | 100.0 |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 9 | - | 100.0 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5 | 5 | - | 100.0 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* * /төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 629,647,047.52 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 629,647,047.52 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 599,404,001.52 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,979,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,979,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 110,062,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 110,062,300.00 |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 30,243,046.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 30,243,046.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 629,647,047.52 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 629,647,047.52 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 629,647,047.52 |

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 6,264.7 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх үеийн үр дүнг 264.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.;
- Санхүүгийн байдлын тайланд дахин үнэлгээний зөрүүг 6,000.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Энэ нь УСНББОУС 24 Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулга, санхүүгийн тайлагналын “ангилал”, “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 3,070.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 3,070.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул  “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт-1:* Нийт 3,070.0 мянган төгрөгийн шатахууны тооцоог бодож, үр дүнг санхүүгийн тайланд илэрхийлээгүй, олгосон талоны дүнгээр зардалд бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Шатахуун зарцуулалтын тооцоог тухай бүр хийж, үр дүнг санхүүгийн тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх үеийн үр дүнг илүү илэрхийлсэн. | 1 | 264.7 | | | 1 | 264.7 | 1 | 264.7 | | | | |
| Санхүүгийн байдлын тайланд дахин үнэлгээний зөрүүг дутуу илэрхийлсэн. | 1 | 6,000.0 | | | 1 | 6,000.0 | 1 | 6,000.0 | | | | |
| **Дүн** | **2** | **6,264.7** | | | **2** | **6,264.7** | **2** | **6,264.7** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нийт 3,070.0 мянган төгрөгийн шатахууны тооцоо бодоогүй. | 1 | 3,070.0 | | | | | 1 | 3,070.0 | | | | |
| **Дүн** | **1** | **3,070.0** | | | | | **1** | **3,070.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 8,916.8 мянган төгрөгийн 6 шийдвэрийг мэдээлээгүй байна. | 1 | 8,916.8 | | | 1 | 8,916.8 | | |
| Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна. | 1 | 71,355.8 | | | | | 1 | 71,355.8 |
| Төсвийн шууд захирагч нь тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулаагүй, мэдээлээгүй байна. | 1 | | | | | | 1 | |
| "Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх" хөтөлбөр, арга хэмжээний 2024 оны төсвийн төслийг боловсруулахдаа хэрэгцээ шаардлагыг үндэслээгүй, суурь судалгаа, шинжилгээ хийгээгүй, эрсдэлийг үнэлээгүй, шалгуур үзүүлэлт тодорхойлоогүй, тооцооллын хамт хүргүүлээгүй байна. | 1 | | | | | | 1 | |
| **Дүн** | **4** | **80,272.6** | | | 1 | 8,916.8 | **3** | **71,355.8** |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | Нийт | 1 | 1 | | | 1 | | | |